



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/805

Булган сум

Газар эзэмших эрх дуусгавар болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.6, 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газар (РД:9012419)-ын эзэмшиж байсан Булган сумын 2 дугаар баг, Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит 1 дүгээр гудамжны 109 тоот хаягт байршилтай, 6308003410 нэгж талбарын дугаартай 520 м² газрын талбайд 20 айлын нийтийн орон сууц баригдаж, ашиглалтад орсон тул уг газрын эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/151 дүгээр захирамжийн Аймгийн Засаг даргын тамгын газарт холбогдох хэсгийг хүчингүйд тооцож, 6308003410 нэгж талбарын хувийн хэргийг хаан, газрын кадастрын мэдээллийн санд холбогдох өөрчлөлтийг хийхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

